Аудитыг 2021 оны 04 дүгээр сарын 06-наас 2021 оны 04 дүгээр сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор Б.Анхтуяа нар гүйцэтгэв.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2020 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/366 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Аймгийн ТЕЗ нь “аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, эрсдэлийн удирдлагаар хангаж, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх” эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант онд хууль тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нэгдүгээр гарын үсгийг 2020.07.16 хүртэл аймгийн Засаг дарга Г.Батсуурь, 2020.07.16-2020.11.04-нийг хүртэл аймгийн Засаг даргын орлогч Ш.Билэггүмбэрэл, 2020.11.04-нөөс аймгийн Засаг дарга Г.Батзам, хоёрдугаар гарын үсгийг 2020.02.03 хүртэл ерөнхий санхүүч У.Занабазар, 2020.02.03-наас ерөнхий санхүүч Б.Соёлмаа нар тус тус зурж ажилласан байна.

Тайлант онд сонгуулийн үр дүнгээр Төсвийн ерөнхийлөн захирагч 3 удаа өөрчлөгдсөн байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нь холбогдох стандарт, журмын дагуу

шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хууль тогтоомж зөрчигдөх зэрэг үр дагавартай байна.

Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 2020 онд санхүүгийн үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль болон Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого заавар, журмыг баримтлан ажилласан байна. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д заасны дагуу “ТЕЗ нар өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1-д зааснаар “ТЕЗ бүр дотоод аудитын алба байгуулж ажиллах” тухай хуулийн заалтуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 23 хяналт шалгалт хийхээс төлөвлөгөөт 17, төлөвлөгөөт бус 8, нийт 25 хяналт шалгалтыг хийсэн байна.

Тайлант хугацаанд 25 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар 827.1 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс нөхөн төлбөрийн 29.3 сая төгрөгийн актыг орон нутгийн орлого болгуулахаар, 3.1 сая төгрөгийн актыг холбогдох хүнд нь буцаан олгуулахаар акт тогтоосон байна. Дээрх хяналт шалгалтын дүнг аймгийн Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлсэн ба актын барагдуулалт 70.8 хувьтай байна.

Тухайн тайлант хугацаанд нийт 102.9 сая төгрөгийн 16 хугацаатай албан шаардлага өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хяналт шалгалт: Тус байгууллагаас Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд байнгын хяналт тавьж ажиллажээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор Сангийн яамнаас нэгдсэн хяналт шалгалт хийснээс гадна аймгийн төсвийн болон ОНӨҮГ, сан, орон нутгаас татаас авч буй хувийн цэцэрлэгүүдийг хамруулан нийт 81 байгууллагын шилэн дансны цахим хуудсанд хяналт шалгалтыг сар бүр тогтмол хийсэн байна.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн хэрэгжилт 95.9 хувьтай байна. Хуулийн хэрэгжилтийг хангаагүй, холбогдох мэдээллээ хугацаанд нь байршуулаагүй зэрэг зөрчилд давхардсан тоогоор 25 байгууллагад албан тоот хүргүүлж, биелэлтийг 100 хувь хангуулан ажиллаж, эхний 3 дугаар улирлын байдлаар шилэн дансны тайлан 100 хувь илгээгдсэн байна.

Мөн байгууллагуудын шилэн дансны мэдээ оруулалтыг тогтмол хянаж байх үүднээс ил тод байдлын самбар ажиллуулсан байна. Дээрх самбарыг иргэдэд нээлттэй ил, тод ажиллуулснаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад байгууллагууд мэдээллийг үнэн зөв бодитой хийж хэвших хандлага нэмэгдсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 2-р улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 27,969.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 279.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 27,802.5 сая төгрөгөөс 2 хувиар тооцож, 556.0 сая төгрөгөөр тооцлоо.

3.5 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,433.9 сая, эцсийн үлдэгдэл 3,054.6 сая төгрөг болж, 1,379.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	4.6	0.9	-3.7
Банканд байгаа бэлэн мөнгө	4,429.3	3,053.7	-1,375.6
Дүн	4,433.9	3,054.6	-1,379.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	331.7	683.7	352.0
Төсөл/ сан	2,209.7	606.5	-1,603.2
Төрийн сан	1,801.2	1,570.7	-230.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	91.3	193.8	102.5
Дүн	4,433.9	3,054.6	-1,379.3

Эх сурвалж Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Касст байгаа бэлэн мөнгөний 0.9 сая төгрөгийн үлдэгдлээс 0.6 сая төгрөг нь “Ус-Ду” ОНӨААТҮГ, 0.3 сая төгрөг нь “Талын-Илч” ОНӨААТҮГ-ын кассын үлдэгдэл байна.

Банкинд байршиж буй нийт 3,053.7 сая төгрөгийн 2,855.4 сая төгрөг нь төрийн санд, 198.3 сая төгрөг нь арилжааны банкинд байршиж байна. Үүнээс: 683.6 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 193.8 сая төгрөг нь төрийн болон ОНӨААТҮГ-ын, 1,570.7 сая төгрөг нь төрийн сангийн, 606.5 сая төгрөг нь төсөл, сангийн үлдэгдэл байна.

- Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 683.6 сая төгрөгийг байгууллагаар нь задалбал: АОНХС-гийн дансанд 181.6 сая, Шивээговь сумын ОНХС-гийн дансанд 66.0 сая, СХС-гийн дансанд 14.2 сая, Баянтал сумын ОНХС-гийн дансанд 24.6 сая, СХС-гийн дансанд 64.3 сая, Сүмбэр сумын ОНХС-гийн дансанд 142.8 сая, СХС-гийн дансанд 96.2 сая, “Энхтүсдэм” өрхийн эрүүл мэндийн төвийн дансанд 5.5 сая, төсвийн байгууллагуудын ахмадын сангийн дансанд 88.4 сая төгрөг тус тус байна.
- Төсөл, сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 606.5 сая төгрөг /аймгийн хөрөнгө оруулалтын барьцаа дансанд 422.5 сая, Шивээговь сумын хөрөнгө оруулалтын барьцаа дансанд 7.9 сая, Баянтал сумын хөрөнгө оруулалтын барьцаа дансанд 7.7 сая, Сүмбэр сумын хөрөнгө оруулалтын барьцаа дансанд 49.0 сая, нэмэлт дансны үлдэгдэл 119.4 сая/
- Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,570.7 сая төгрөг /Ерөнхий орлогын үлдэгдэл аймагт 1,199.0 сая, Сүмбэр суманд 293.0 сая, Шивээговь суманд 46.5 сая, Баянтал суманд 32.2 сая/
- ОНӨААТҮГ-ын арилжааны банкны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 193.8 сая төгрөг /“Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ 71.2 сая, “Ус-Ду” ОНӨААТҮГ 120.8 сая, “Илчлэг Шивээ” ОНӨААТҮГ 0.8 сая, “Талын-Илч” ОНӨААТҮГ 1.0 сая/ тус тус байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,801.2 сая, эцсийн үлдэгдэл 1,570.7 сая төгрөг болж, 230.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа мөнгөн хөрөнгө			
Төрийн сан	1,801.2	1,570.7	-230.5
Нийт дүн	1,801.2	1,570.7	-230.5

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн эхний үлдэгдэл 1,801.2 сая төгрөг байснаас тайлант онд орон нутгийн төсвийн татварын орлого 5,744.0 сая төгрөг, татварын бус орлого 702.5 сая, Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 9,333.6 сая, ОНХС-гийн санхүүжилт 1,016.0 сая, улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг 2,145.0 сая, төсөвт байгууллагын төвлөрүүлэх шилжүүлэг 637.4 сая, нийт 19,578.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, харьяа байгууллагуудын урсгал болон хөрөнгө оруулалтын санхүүжилтэд нийт 19,809.0 сая төгрөгийг зарцуулж, 1,570.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой нийт 40.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Сүмбэр сумын ТТЗ-ийн харьяа 4 байгууллагын эдийн засгийн ангилал зөрчсөн 21.5 сая төгрөгийн ажил гүйлгээг хийж гүйцэтгэсэн, Төрийн сангийн төлбөр тооцооны журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй.
- Шивээговь сумын ОНХС нь Гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх ажилд анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 1.1 сая төгрөгийг зарцуулсан
- Сүмбэр сумын ОНХС нь Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах санхүүжилтийн 6.7 сая төгрөгийн гэрээнд дарга гарын үсэг зураагүй, хүлээн авах огноог тусгаагүй
- Сүмбэр сумын ТТЗ нь хууль бус эрх зүйн чадамжгүй шийдвэрээр сумын ЗДТГ-т тэтгэмж, сургууль, цэцэрлэгүүдэд үр дүнгийн урамшуулал давхардуулан олгож, 6.3 сая төгрөгийн зөрчил гаргасан, зөрчлийг давтан гаргахгүй байх, илт хууль бус шийдвэр гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж өгсөн
- Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 5.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: Шивээговь сумын 3-р сургууль 0.4 сая, 1 дүгээр цэцэрлэг 3.4 сая, 2 дугаар цэцэрлэг 1.4 сая төгрөгийн бохирын худаг цэвэрлэсэн ажлын хөлс болон хог хаягдлын зардлыг тогтмол зардлаас буюу цэвэр бохир усны зардлаас зарцуулсан.
- ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагууд Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтын үнийн дүнг тулган баталгаажуулж хяналт тавьж ажиллаагүй

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат хөрөнгө оруулалт бүртгэгдээгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1,851.8 сая, эцсийн үлдэгдэл 1,914.4 сая төгрөг болж 62.6 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь тайлант онд болон өмнөх онуудад олгосон сумдын Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүйгээс тооцооллын алдаа гаргаж, ажиллагсадтай холбогдсон болон бусад авлага нэмэгдсэн байна.

Хүснэгт №.3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	16.8	11.6	-5.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	1.5	48.7	47.2
Татаас, санхүүжилтийн авлага	4	0.0	-4.0
Зээлийн хүүгийн авлага	43.2	43.1	-0.1
Дансны авлага /ТӨҮГ/	21.6	30.3	8.7
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	3.3	2.6	-0.7
Бусад авлага	1,761.40	1,778.1	16.7
Дүн	1,851.80	1,914.4	62.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			0.0
Төсөвт байгууллага	1,650.00	1,472.0	-178.0
Төсөл/ сан	6.4		-6.4
Төрийн сан	0		0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	195.4	442.5	247.1
Дүн	1,851.80	1,914.4	62.6

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдлийг нэр, төрлөөр нь задалж харуулбал:

- 1 Ажиллагсадтай холбогдсон авлага 11.6 сая /аймгийн Ахмадын хороо 0.1 сая, “Илчлэг-Шивээ”ОНӨҮГ 0.3 сая, “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ-ын 6.2 сая, ГБХЗХГ-ын 0.2 сая, АЗДТГ-ын 0.3 сая, Шивээговь сумын ИТХ-ын 0.1 сая, ЗДТГ-ын 0.1 сая, Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 0.7 сая, ЭМТ-ийн 1.1 сая, Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 1.5 сая, 1 дүгээр сургуулийн 0.2 сая, ИТХ-ын 0.1 сая, 5 дугаар сургуулийн 0.6 сая, “Энхтусдэм” өрхийн эрүүл мэндийн төвийн 0.1 сая/
- 2 Төлбөртэй үйлчилгээний авлага 48.7 сая /Сүмбэр сумын СХС-гийн зээлийн алдангийн авлага/
- 3 Зээлийн хүүгийн авлага 43.1 сая /Шивээговь сумын СХС-гийн 8.1 сая, Баянтал сумын СХС-гийн 0.01 сая, Сүмбэр сумын СХС-гийн 35.0 сая/
- 4 Дансны авлага /ТӨҮГ/ 30.3 сая /“Талын-Илч” ОНӨААТҮГ-ын халаалтын авлага/
- 5 Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/ 2.6 сая /“Талын –Илч” ОНӨААТҮГ-ын 2.6 сая/
- 6 Бусад авлага 1,778.1 сая, үүнээс: байгууллагаас авах авлага 525.4 сая /“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 349.4 сая, АЗДТГ-ын 45.0 сая, “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ-ын 9.0 сая, аймгийн ГБХЗХГ-ын 1.3 сая, “Тохижилт-сүмбэр” ОНӨААТҮГ-ын 27.4 сая, “Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын 28.0 сая, АОНХС-гийн 47.3 сая, Баянтал сумын 4 дүгээр сургуулийн 0.1 сая, 4 дүгээр цэцэрлэгийн 2.1 сая, ОНХС 9.5 сая/
- 7 Хувь хүнээс авах авлага 1,252.7 сая төгрөг/ “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 4.3 сая, АИТХ-ын 2.2 сая, Шивээговь сумын СХС-гийн 167.3 сая, ЗДТГ-ын 5.6 сая, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн 1.0 сая, Сум хөгжүүлэх сангийн 904.0 сая, 2 дугаар цэцэрлэгийн 0.3 сая, Баянтал сумын 4 дүгээр сургуулийн 15.0 сая, 4 дүгээр цэцэрлэгийн 0.6 сая, ЭМТ-ийн 0.6 сая, ЗДТГ-ын 4.9 сая, Сум хөгжүүлэх сангийн 146.9 сая/

Хүснэгт №4. Авлагыг аймаг, сумдаар нь харуулбал

/сая төгрөг/

Аймаг, сумдын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар	Нийт үлдэгдэлд эзлэх хувь
Аймаг	279.2	554.0	274.8	98	29
Сүмбэр сум	1,055.00	997.6	-57.4	-5	52
Баянтал сум	396.1	181.5	-214.6	-54	9
Шивээговь сум	121.5	181.3	59.8	49	9
НИЙТ ДҮН	1,851.80	1,914.4	62.6	3	100.00

Хүснэгтээс харахад: Өмнөх оноос аймгийн авлага 98%, Шивээговь сумын авлага 49%-иар тус тус нэмэгдэж, Баянтал сумын авлага 54%, Сүмбэр сумын авлага 5%-иар тус тус буурсан байна

Мөн нийт авлагын 29%-ийг аймаг, 52%-ийг Сүмбэр сум, 9%-ийг Баянтал сум, 9%-ийг Шивээговь сум тус тус эзэлж байна.

Авлагын үлдэгдэлд 0-1 жил хүртэлх 95.4 сая, 1-2 жил хүртэлх 428.6 сая, 2-3 жил хүртэлх 5.9 сая, 3-4 жил хүртэлх 143.3 сая, 5 жилээс дээш хугацаатай 1,241.0 сая төгрөгийн авлага тус тус байна.

Авлагын үлдэгдлийн 1,690.3 сая төгрөг буюу 88.2 хувийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

Авлагын данстай холбоотой материаллаг нийт 201.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

- Цөм сүргийн үржлийн төв нь санхүүгийн тайланд тусгагдсан 9.0 сая төгрөгийн авлагыг бууруулж ажиллаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй
- Баянтал сумын СХС нь зээлийн хүү болон алданги төлөлтийг үндсэн зээл төлөлтөөс хассантай холбоотой 8.7 сая төгрөгийн зээлийн авлагыг дутуу бүртгэсэн.
- Баянтал сумын ЗДТГ нь санхүүгийн үр дүнгийн тайланд өвсний авлагаас төлөгдсөн 8.3 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн.
- Шивээговь сумын СХС нь өмнөх оны зээлийн хүүгийн үлдэгдлээр авлага үүсгээгүй, тайлант онд олгосон зээлийн хэмжээгээр авлага үүсгэсэн. Зээлийн хүүг үнэн зөв тооцоогүй, 175.5 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 68.4 сая, эцсийн үлдэгдэл 129.8 сая төгрөг болж 61.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	2.5	0.7	-1.8
Төсөвт байгууллага	41.9	108.1	66.2
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1.0	1.0	0.0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	15.0	15.0	0.0
Цалингийн урьдчилгаа	8.0	5.0	-3.0
Томилолтын урьдчилгаа	0.0		0.0
Дүн	68.4	129.8	61.4
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	68.4	129.8	61.4
ТӨҮГ болон ОНӨҮГ			
Дүн	68.4	129.8	61.4

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд өмнөх онд үүссэн 21.0 сая, 2020 онд үүссэн 108.8 сая, нийт 129.8 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. Үүнд: төсөвт байгууллагын урьдчилгааны үлдэгдэл 83%, үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа 12%, цалингийн урьдчилгаа 4%, бараа материал бэлтгэх болон урьдчилж гарсан зардал 1%-ийг тус тус эзэлж байна.

Төсөвт байгууллагын урьдчилгаа дансны үлдэгдэл 108.1 сая төгрөгийг байгууллагаар нь харуулбал:

- аймгийн БТСГ-ын төвлөрүүлсэн санхүүжилт 13.1 сая
- аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэл санхүүжилт 4.0 сая
- аймгийн БОАЖГ-ын хөтөлбөрийн төвлөрүүлсэн санхүүжилт 1.0 сая
- Сүмбэр сумын шилдэг сумын урамшуулал 90.0 сая

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 0.7 сая төгрөг нь Шивээговь сумын ОНХС-гийн туурь хог цэвэрлэх ажилд урьдчилж гаргасан шатахууны зардал тайланд онд ажил хийгдээгүйтэй холбоотой үүссэн байна.

Бараа материал болон үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа нь Аймгийн авто замын сангийн ажлын 16.0 сая төгрөг байна.

Цалингийн урьдчилгааны 5.0 сая төгрөг нь 4 байгууллагын цалингийн урьдчилгаа тусгагдсан байна. Тухайлбал: Баянтал сумын ЗДТГ-ын 0.3 сая, 4 дүгээр цэцэрлэгийн 0.2 сая, Эрүүл мэндийн төвийн 4.0 сая, Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэгийн 0.5 сая төгрөгийн үлдэгдлүүд байгаа бөгөөд эдгээр нь тооцооллын алдаа гаргаж, урьдчилгааг дутуу суутгаснаас үүссэн байна.

Аудитын илрүүлэлт:

Урьдчилгаа данстай холбоотой материаллаг нийт 16.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн Автозамын сан нь Бараа материал болон үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгааны 16.0 сая төгрөгийг барагдуулж ажиллаагүй
- Шивээговь сумын ОНХС нь Туурь хог хаягдал цэвэрлэх нөхөн сэргээх ажлын шатахууны урьдчилж гарсан зардлыг нөөцийн бараагаар бүртгэсэн

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт бүртгэлгүй байна.

3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 3,503.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,211.4 сая төгрөг болж, 708.3 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд аймаг, сумдын ОНХС болон харьяа дээд байгууллагуудаас үнэ төлбөргүй бараа материал хүлээн авсантай холбоотой байна.

Хүснэгт №6. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	295.7	352.3	56.6
Дуусаагүй үйлдвэрлэл		0.0	0.0
Бэлэн бүтээгдэхүүн	0.6	5.2	4.6
Хангамжийн материал	2,751.7	3,395.8	644.1
Мал амьтад	455.1	458.1	3.0
Дүн	3,503.1	4,211.4	708.3
Үүнээс, байгууллагын төрлөөр			

Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсөвт байгууллага	3,291.4	3,951.6	660.1
Төсөл/ сан	0.0	0.0	0.0
Төрийн сан	0.0	0.0	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	211.6	259.8	48.2
Дүн	3,503.1	4,211.4	708.3

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эхний үлдэгдэл 3,503.1 сая төгрөг байсан ба худалдан авсан 2,022.8 сая төгрөг, хандиваар авсан 126.4 сая төгрөг, шилжүүлж авсан 467.0 сая төгрөг, бараа үнэ төлбөргүй авсан 491.6 сая, нийт 3,107.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 1,924.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 171.2 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, бусад 303.4 сая, нийт 2,399.5 сая төгрөгөөр хасагдаж, 4,211.4 сая төгрөгийн бараа материалыг үлдэгдлээр тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материалын данстай холбоотой нийт 237.8 сая төгрөгийн материаллаг алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн БОАЖГ нь бусад хангамжийн материалаас үндсэн хөрөнгөнд шилжүүлсэн 77.8 сая төгрөгийн хөрөнгийг үр дүнгийн тайланд орлого, зарлагаар бүртгэсэн
- Аймгийн Боржигин чуулга нь бараа материалын тайланд анхан шатны баримтын бүрдэлгүй 11.2 сая төгрөгийн бичиг хэрэг, аж ахуй, сэлбэг хэрэгсэл, барилгын засварын материалыг зарцуулснаар тайлагнасан
- Баянтал сумын Эрүүл мэндийн төв нь бараа материалын тайланг хянаагүй гарын үсэг зурж баталгаажуулаагүй, анхан шатны баримтад үндэслээгүй, баримтын бүрдэл хангаагүй, бараа материалын тайлан бэлтгээгүй санхүүгийн тайланд хүчин төгөлдөр бус баримтаар 31.0 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэж тайлагнасан.
- Баянтал сумын ЗДТГ нь санхүүгийн үр дүнгийн тайланд худалдан борлуулсан 8.2 сая төгрөгийн өөсийг зардлаар тайлагнасан.
- Шивээговь сумын 3-р сургууль нь бараа материалыг данс хооронд шилжүүлсэн 32.7 сая төгрөгийг материалыг буруу тайлагнаж, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг нэмэгдүүлсэн
- Төсвийн зардлын үлдэгдлийг буцаан төвлөрүүлэлгүй, үндсэн үйл ажиллагааны хэрэгцээнээс илүүдэл 16.7 сая төгрөгийн шатахууны нөөц бүрдүүлсэн/ АЗДТГ 13.3 сая, БОАЖГ 1.8 сая, ОНӨГ 1.6 сая /
- Цөм сүргийн үржлийн төв нь ОНХО-ын хөрөнгөөр хонь худалдан авч өгсөн 20.0 сая төгрөгийн орлогыг хандиваар бүртгэсэн, малын нас дэвшилт болон хурганы арьсны орлого 25.3 сая төгрөгийг худалдан авсан бараа материалаар бүртгэсэн
- Бараа материалыг санхүүгийн тайланд 67.8 сая төгрөгөөр ангилал зөрүүтэй тайлагнасан /1-р сургууль 17.4 сая, 2 дугаар цэцэрлэг 7.8 сая, "Энхтүсдэм" өрхийн эрүүл мэндийн төв" 27.0 сая, Баянтал сумын ЗДТГ 3.2 сая, Баянтал сумын 4-р цэцэрлэг 7.1 сая, аймгийн ГБХЗХГ 5.3 сая/

Нөөцийн барааны эхний үлдэгдэл 87.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 66.6 сая төгрөг болж, 20.7 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь сумдын ОНХС-гаас өвс тэжээлийн нөөцийг зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт № 7 Нөөцийн бараа үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барааны нөөц	23.0	0	-23.0
Тэжээлийн нөөц	45.5	37.9	-7.6
Бусад нөөц	18.8	28.6	9.8
Дүн	87.3	66.6	-20.7

<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	87.3	66.6	-20.7
Төсөл/ сан			0.0
Дүн	87.3	66.6	-20.7

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын нөөцийн барааны үлдэгдлийг байгууллагаар нь харуулбал:

- Баянтал сумын ЗДТГ-ын өвс тэжээл 13.7 сая,
- Сүмбэр сумын ЗДТГ-ын өвс тэжээл 24.2 сая,
- Шивээговь сумын ЗДТГ-ын өвс тэжээл 7.0 сая
- Шивээговь сумын Эрүүл мэндийн төвийн нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл 12.7 сая,
- Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн ном 9.0 сая төгрөг тус тус байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 40,356.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 43,463.6 сая төгрөг болж, 3,107.0 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймаг сумдын ОНХС-гаас хөрөнгө хүлээн авсантай холбоотой байна.

Хүснэгт №. 8 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг / Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	21,875.6	21,682.5	-193.1
Авто-тээврийн хэрэгсэл	758.6	1,461.6	703.1
Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,311.1	4,249.5	938.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	708.6	944.0	235.5
Зам, гүүрийн байгууламж	2,737.1	2,618.6	-118.5
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	82.2	86.5	4.3
Бусад үндсэн хөрөнгө	4,118.1	5,550.0	1,431.9
Дуусаагүй барилга, байгууламж	40.7	40.7	0.0
Биет бус хөрөнгө	6,569.8	6,634.3	64.5
Ном	154.8	195.9	41.1
Дүн	40,356.6	43,463.6	3,107.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	26,583.2	28,433.5	1,850.3
ТӨҮГ болон ОНӨҮГ	13,773.3	15,030.1	1,256.7
Дүн	40,356.6	43,463.6	3,107.0

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаанд нийт 7,104.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн ба үүнээс худалдан авсан 265.6 сая, хандив тусламжаар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 91.8 сая, шилжүүлж авсан 1,097.8 сая, ОНӨҮГ-ын хөрөнгийн орлого 4,759.0 сая, дахин үнэлгээгээр 890.2 сая төгрөг тус тус нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд нийт 4,331.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдсан ба үүнээс худалдсан 8.5 сая, шилжүүлсэн 1,310.6 сая, акталсан 933.9 сая, дахин үнэлгээний хорогдол 2,027.7 сая, ОНӨҮГ-ын хөрөнгийн зарлага 51.0 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 40.7 сая төгрөг нь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын барилгын зураг 15.7 сая, Баянтал сумын ЗДТГ-т бүртгэлтэй сумын уурын зуухны зураг 10.0 сая, "Илчлэг-Шивээ" ОНӨААТҮГ-ын барилгын өргөтгөлийн зураг 15.0 сая төгрөг тус тус байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой материаллаг нийт 506.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

- Шивээговь сумын Соёлын төв нь тайлант хугацаанд 58.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн нярвын тайлан бэлтгэн гаргаагүй
- Баянтал сумын ЭМТ нь үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй өртгөө элэгдлээрээ нөхсөн 32 нэр төрлийн 78.0 сая төгрөгийн хөрөнгийг актлах болон ашиглах боломжтой хөрөнгийг үнэлгээ тогтоож бүртгээгүй.
- Шивээговь сумын 3-р сургууль нь ашиглалтын хугацаа дууссан 89.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгүүдийг дахин үнэлэхдээ хуучин үнээр нь дахин бүртгэсэн
- Үндсэн хөрөнгийг ангилал зөрүүтэй бүртгэсэн нийт 295.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд /Шивээговь сумын ЗДТГ 115.0 сая, Сүмбэр сумын 5 дугаар сургууль 42.6 сая, 2 дугаар цэцэрлэг 3.9 сая, 5 дугаар цэцэрлэг 21.0 сая, 6 дугаар цэцэрлэг 20.5 сая, Баянтал сумын 4 дүгээр сургууль 10.6 сая, цэцэрлэг 23.8 сая, Соёлын төв 14.5 сая, Боржигин чуулга 34.0 сая, БОАЖГ нь 9.7 сая/

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 5,327.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,318.0 сая төгрөг болж, 990.4 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үлдэгдэл санхүүжилтийг өглөгөөр тусгасан, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүйгээс тооцооллын алдаа гаргасан зэргээс өглөг нэмэгдсэн байна.

Хүснэгт № 9 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	2,492.70	1,412.7	-1,080.0
Ажилчидтай холбогдсон өглөг	20	1.9	-18.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	11.5	9.7	-1.8
Байгууллагад төлөх өглөг	2,454.50	1,380.9	-1,073.6
Хувь хүмүүст төлөх өглөг	6.7	2.0	-4.7
Татвар, НДШ-ийн өглөг		18.0	18.0
Урт хугацаат өр төлбөр дүн	2,834.90	4,905.3	2,070.4
Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	2,834.90	4,905.3	2,070.4
Нийт дүн	5,327.60	6,318.0	990.4
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	147.9	73.3	-74.6
Төсөл, сан	2,190.90	595.1	-1,595.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,988.80	5,649.6	2,660.8
ДҮН	5,327.60	6,318.0	990.4

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс харахад: Богино хугацаат өр төлбөр нийт 1,080.0 сая төгрөгөөр буюу 43.3%-иар буурч, урт хугацаат өглөг 2,070.4 сая төгрөгөөр буюу 73.0%-иар өссөн байна.

Хүснэгт № 10 Өглөгийн үлдэгдлийг аймаг, сум тус бүрээр харуулбал:


/сая төгрөг /

д/д	Сумдын нэр	Нийт өр төлбөр		Зөрүү	Нийт дүнд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
1	Сүмбэр сум	56.2	139.9	83.7	10.0
2	Баянтал сум	46.4	13.7	-32.7	1.0
3	Шивээговь сум	23.4	14.1	-9.3	1.0

4	Говьсүмбэр аймаг	2,366.7	1,245.0	-1,121.7	88.0
	Дүн	2,492.7	1,412.7	-1,080.0	100.0

Хүснэгтээс харахад: Тайлант оны өглөгийн үлдэгдэл өмнөх оноос нийт 1,080.0 сая төгрөгөөр буурсан бөгөөд аймаг 1,121.7 сая, Шивээговь сум 9.3 сая, Баянтал сум 32.7 сая төгрөгөөр тус тус буурч, Сүмбэр сумын өглөг 83.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Сүмбэр сумын өглөг нэмэгдсэн нь шилдэг сумын шагналыг нэмэлт дансанд төвлөрүүлж авлага, өглөг үүсгэснээс шалтгаалжээ.

ТЕЗ-ийн нийт өр төлбөрт эзэлж байгаа хувь хэмжээг аймаг, сумдаар нь диаграммаар харуулбал:



Диаграммаас харахад: Нийт өр төлбөрийн 10%-ийг Сүмбэр сум, 1%-ийг Баянтал сум, 1%-ийг Шивээговь сум, 88%-ийг аймгийн төвийн байгууллагууд эзэлж байна.

Хүснэгт № 11 Өглөгийн үлдэгдэл байгууллагын төрлөөр:

№	Байгууллагуудын төрөл	Эцсийн үлдэгдэл	Нийт дүнд эзлэх хувь
1	Орон нутгийн төсөвт байгууллага	108.2	7.7
2	Аймаг, сумдын хөрөнгө оруулалтын барьцаа	487.0	34.5
3	Тусгай сангийн өглөг	32.2	2.3
4	Тусгай шилжүүлгийн байгууллагууд	6.5	0.5
5	Аймаг, сумдын ОНХС	23.5	1.7
6	ОНӨААТҮГ	755.3	53.5
	Дүн	1,412.7	100

Хүснэгтээс харахад: Нийт өр төлбөрийн 53.5%-ийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, 34.5%-ийг аймаг, сумдын хөрөнгө оруулалтын барьцааны өглөг, 7.7%-ийг орон нутгийн төсөвт байгууллагууд, 2.3%-ийг тусгай сангийн өглөг, 1.7%-ийг аймаг, сумдын ОНХС-гийн өглөг, 0.5%-ийг тусгай шилжүүлгийн байгууллагууд тус тус эзэлж байна.

Өглөгийн үлдэгдлийг байгууллага тус бүрээр болон төрлөөр нь ангилбал дараах байдалтай байна. Үүнд:

- Орон нутгийн төсөвт байгууллагын өглөгийн үлдэгдэл нийт 108.2 сая төгрөг /Шивээговь сумын ЗДТГ болон ИТХ-ын 0.1 сая, аймгийн БТСГ-ын 13.1 сая, АЗДТГ-ын 4.0 сая, БОАЖГ-ын 1.0 сая, Сүмбэр сумын ЗДТГ-ын 90.0 сая/
- Аймаг, сумдын барьцаа дансны хөрөнгө оруулалтын барьцааны өглөг нь аймагт 422.4 сая, Шивээговь сумын 7.9 сая, Сүмбэр сумын 49.0 сая, Баянтал сумын 7.7 сая төгрөг байна.
- Тусгай сангийн өглөг нь аймгийн Автозамын сангийн хөрөнгө оруулалтын ажлын өглөг 32.2 сая төгрөг байна.
- Тусгай шилжүүлгийн байгууллагын өглөгийн үлдэгдэл нийт 6.5 сая төгрөг бөгөөд аймгийн Нийтийн номын сангийн 0.6 сая, Шивээговь сумын 3 дугаар сургууль, Соёлын төвийн 0.1 сая, Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн 0.7 сая, 1 дүгээр

сургуулийн 0.3 сая, Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2.6 сая, Эрүүл мэндийн төвийн 2.2 сая төгрөг байна.

- Аймаг, сумдын ОНХС-гийн өглөгийн үлдэгдэл нийт 23.5 сая төгрөг бөгөөд аймгийн ОНХС-гийн 16.3 сая, Шивээговь сумын ОНХС-гийн 6.0 сая, Баянтал сумын ОНХС-гийн 1.2 сая төгрөг байна.
- ОНӨААТҮГ-ын өглөгийн үлдэгдэл нийт 755.3 сая төгрөг бөгөөд аймгийн “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ-ын 11.0 сая, “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 471.3 сая, “Тохижилт-сүмбэр” ОНӨААТҮГ-ын 0.8 сая, “Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын 230.6 сая, “Талын-Илч” ОНӨААТҮГ-ын 41.6 сая төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд тусгагдсан 4,905.3 сая төгрөг нь ОНӨҮГ-уудын хойшлогдсон татварын өглөг бөгөөд “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2,184.6 сая, “Тохижилт-сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2,010.0 сая, “Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын 57.1 сая, “Талын-Илч” ОНӨААТҮГ-ын 653.6 сая төгрөг тус тус тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Өглөгийн данстай холбоотой материаллаг нийт 12.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

- “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ нь НДШ-ийн болон гэрэл цахилгаан, бусад зардлын тооцооны өглөгийг 3.4 сая төгрөгөөр хасах дүнгээр тайлагнасан
- Сүмбэр сумын ЗДТГ нь тайлант хугацаанд бичиг хэрэг, томилолт, урсгал засварын зардалд 8.7 сая төгрөгийн өглөг үүсгэсэн

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцооны дансны эхний үлдэгдэл 45,901.6 сая, эцсийн үлдэгдэл 46,622.7 сая төгрөг болж 721.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт+/, бууралт -/
Засгийн газрын оруулсан капитал /ЗГТС/ ОНТС	25,082.2	25,124.2	42.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	1,224.0	1,224.0	0.0
Хуримтлагдсан үр дүн	7,641.0	7,882.9	241.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,954.4	12,391.6	437.2
Дүн	45,901.6	46,622.7	721.1

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтэд харуулснаар дансдын үзүүлэлтээрх өөрчлөлтийн тайлбар дараах байдалтай байна. Үүнд:

1. Засгийн газрын оруулсан капитал дансны өөрчлөлт 42.0 сая төгрөг нь Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэг 21.9 сая, аймгийн ГБХЗХГ 18.0 сая, “Талын илч”-ОНӨААТҮГ 2.1 сая төгрөгөөр тус тус шинээр эзэмшлийн газар бүртгэж нэмэгдсэн байна.
2. Тайлант онд хуримтлагдсан үр дүн данс нийт 241.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс 230.0 сая төгрөг нь тайлант хугацааны үр дүн, 11.9 сая төгрөг нь 15 байгууллагын бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байна.
3. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 437.2 сая төгрөг нь 17 байгууллагын хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээр өөрчлөгдсөн байна.

3.5.10 Орлогын данс

Орлого үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн үйл ажиллагааны орлогод нийт 110.2 сая, /сум хөгжүүлэх сангийн орлого 59.4 сая, мал хамгаалах сангийн орлого 1.1 сая,

БТСГ, ЦСҮТ-ийн өөрийн орлого 39.1 сая, ГХБХБГ-ын орлого 10.5 сая, туслах үйл ажиллагааны орлогод нийт 146.6 сая /сум хөгжүүлэх сангийн орлого 0.2 сая, авто замын сан болон АЗДТГ-ын өөрийн орлого 19.5 сая, өрхийн эрүүл мэндийн төвийн орлого 11.0 сая, халамжийн сангийн орлого 0.3 сая, ахмадын сангийн орлого 115.6 сая/ төгрөгийг тус тус тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогод нийт 224.3 сая, /сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлого 160.2 сая, мал хамгаалах сангийн орлого 1.9 сая, БТСГ, ЦСҮТ-ийн өөрийн орлого 39.1 сая, ГХБХБГ-ын орлого 10.5 сая, усны орлого 12.6 сая/, туслах үйл ажиллагааны орлогод нийт 241.2 сая /сум хөгжүүлэх сангийн орлого 9.9 сая, өрхийн эрүүл мэндийн төвийн орлого 11.0 сая, авто замын сан болон АЗДТГ-ын өөрийн орлого 19.4 сая, хог хаягдал усны орлого 95.5 сая, халамжийн сангийн орлого 0.3 сая, ГХБХБГ-ын орлого 32.6 сая, ахмадын сангийн орлого 72.5 сая/ төгрөгийн орлогыг тус тус тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Орлогын данстай холбоотой материаллаг нийт 91.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

- *“Тохижилт сүмбэр” ОНӨААТҮГ нь хог хаягдлын хураамжийн давсан орлого 13.2 сая төгрөгийг сумын орон нутгийн орлогод бүрэн төвлөрүүлээгүй,*
- *СХС-гийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй /Шивээговь сумын СХС 12.0 сая, Сүмбэр сумын СХС-11.4 сая/*
- *Шивээговь, Сүмбэр сумын татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр биелүүлээгүй /Сүмбэр сум 17.7 сая, Шивээговь сум 28.2 сая/*
- *Баянтал сумын СХС нь санхүүгийн үр дүнгийн тайланд хүү, алдангийн орлогыг 9.0 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн*

3.5.11 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 189.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь төсвийг үндэслэлгүй төлөвлөсөн, хөрөнгө оруулалтын ажлыг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, хууль эрхийн актгүй шагнал олгосон, хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан, санхүүгийн тайланд зардлыг ангилал зөрүүтэй тайлагнасан зөрчлүүд байна.

Аудитын илрүүлэлт:

Зарлагын данстай холбоотой материаллаг нийт 189.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

- *“Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ нь мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө худалдан авсан 10.4 сая төгрөгийн зардлыг тусад нь тайлагнаагүй,*
- *Аймгийн Автозамын сан нь авто замын их засварын ажил гүйцэтгэх 32.1 сая төгрөгийн гэрээний хугацааг 2020.06.02 хүртэл сунгасан боловч сунгалтын хугацаа дууссан байхад ажлыг хүлээн аваагүй,*
- *Сүмбэр сумын ЗДТГ нь Улсын тэргүүний сум болсонтой холбогдуулан цалингийн зардлаас зориулалт бусаар 26 албан хаагчид 14.5 сая төгрөгийн шагнал олгосон,*
- *Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг нь даргын тушаалгүй буюу эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр Ковид-19-ийн халдвараас урьдчилсан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой 3.5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан*
- *АЗДТГ нь 6.3 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулж, хөрөнгө бэлтгэсэн*
- *Санхүүгийн үр дүнгийн тайланд 3 байгууллага нийт 112.2 сая төгрөгийн зардлыг ангилал зөрүүтэй тайлагнасан. Үүнд: АЗДТГ 95.4 сая, “Энхтүсдэм” өрхийн эрүүл мэндийн төв 13.7 сая, Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэг 3.1 сая/*

- Шивээговь сумын 3 дугаар сургууль нь төлөвлөлттэй холбоотой зарцуулаагүй үлдсэн үлдэгдэл төсвийн зардлыг буцаан төвлөрүүлэлгүй, зориулалт бусаар 10.8 сая төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны 08, Сүмбэр сумын ИТХ-ын 2020 оны 05, Шивээговь сумын ИТХ-ын 08, Баянтал сумын ИТХ-ын 06 дугаар тогтоолоор тайлант онд 5,618.2 сая төгрөгийн татварын болон татварын бус орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 6,456.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 14.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого	3,220.0	3,736.7	516.7	16.0
Үйл ажиллагааны орлого	54.4	46.2	8.2	-15.1
Хөрөнгө борлуулсны орлого	260.0	271.0	11.0	4.2
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	45.0	70.8	25.8	57.3
Шууд бус орлого	148.6	294.9	146.3	98.5
Хувь хүний орлогын албан татварын буцаалт	-195.4	-195.4	0.0	-
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	405.0	373.8	31.2	-7.7
Бууны албан татвар	5.4	5.0	0.4	-7.4
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	105.0	113.3	8.3	7.9
Улсын тэмдэгтийн хураамж	83.1	74.2	8.9	-10.7
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	30.5	15.1	15.4	-50.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	102.9	114.8	11.9	11.6
Газрын төлбөр	230.0	269.7	39.7	17.3
Дуудлага худалдаа	114.3	195.5	81.2	71.0
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	18.5	18.5	0.0	-
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	340.0	350.6	10.6	3.1
Түрээсийн орлого	61.0	51.7	9.3	-15.2
Хүү, торгуулийн орлого	590.0	650.3	60.3	10.2
Нийт дүн	5,618.2	6,456.8	838.6	14.9

Тайлант оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 14.9 хувиар давж биелсэн боловч орлогын нэр төрлөөрөө 10 нэр төрлийн орлого нийт 1,501.8 сая төгрөгөөр давж, 6 орлогын төлөвлөгөө нийт 73.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Давсан орлого нь “Шивээ-овоо” ХК 2019 оны цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татварыг барагдуулсан, Хас банк 2019 оны хадгаламжийн хүүний орлогыг барагдуулсан, иргэн бүрд Эрдэнэс-таван толгой ХК-аас олгосон 1072 хувьцааны ногдол ашгаас суутгасан албан татварын төлөлт, өмнөх оны газрын төлбөр барагдсан, төлөвлөгдөөгүй дуудлага худалдааны орлого төвлөрүүлсэн зэргээс шалтгаалсан байна. Үүнд:

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого 516.7 сая,
- хөрөнгө борлуулсны орлого 11.0 сая,
- хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 25.8 сая,

- шууд бус орлого 146.3 сая,
- авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 8.3 сая,
- хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 11.9 сая,
- газрын төлбөр 39.7 сая,
- дуудлага худалдааны орлого 81.2 сая,
- ус рашааны нөөц ашигласны төлбөр 10.6 сая,
- хүү, торгуулийн орлого 650.3 сая төгрөгөөр тус тус давсан байна.

Харин тасарсан орлого нь улсын хэмжээнд ковид-19 цар тахалтай холбогдуулан татвар төлөгчийн тоо буурсан, “Шивээ-овоо” ХК үл хөдлөх эд хөрөнгийн татвар барагдуулаагүй, улсын тэмдэгтийн хураамжийг шүүгчийн захирамжаар татвар төлөгчид буцаан олгосон, түрээсийн орлого дутуу төвлөрсөн, орлогын төлөвлөлтийн үндэслэл бодит бус зэргээс шалтгаалсан байна. Үүнд:

- үйл ажиллагааны орлого 8.2 сая,
- үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 31.2 сая,
- бууны албан татвар 0.4 сая,
- улсын тэмдэгтийн хураамж 8.9 сая,
- түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 15.4 сая,
- түрээсийн орлого 9.3 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн төлөвлөлт

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 9,794.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 9,794.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сангийн яам Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,345.5 сая төгрөгөөр бууруулж, 7,448.7 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Төсвийн төслөөс аймгийн БОАЖГ-ын төсвийг 3.8 сая, Автозамын сангийн төсвийг 4.5 сая, Мал эмнэлгийн вакцины зардлыг 33.3 сая, ГБХЗХГ-ын тогтмол зардлыг 4.4 сая, ЕБС-ын тогтмол зардлыг 326.3 сая, Шивээговь сумын Соёлын төвийн зардлыг 16.9 сая, нийт 389.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, аймгийн ЗДТГ-ын төсвийг 971.7 сая, БТСГ-ын төсвийг 359.5 сая, ИТХ-ын төсвийг 159.3 сая, бусад 22 байгууллагын төсвийг 1,244.2 сая, нийт 2,734.7 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

УИХ-аар батлагдсан Төсвийн тухай хуулиар орон нутгийн 2020 оны төсвийн нийт зарлагыг 18,150.2 сая төгрөгөөр баталсан. Үүнд:

- Төсвийн суурь зарлагыг 7,448.7 сая
- Тусгай зориулалтын шилжүүлгийн зарлага 9,481.1 сая,
- ОНХС-ийн зарлага 1,220.4 сая төгрөг байна.

Аймгийн ИТХТ-ийн 2019.11.29-ний өдрийн 09 дугаар тогтоолоор аймгийн 2020 оны төсвийг батлахдаа УИХ-аас баталсан төсвийг 2,650.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 20,800.7 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор аймгийн ИТХТ-ийн 2020.09.18-ны өдрийн 08 дугаар тогтоолоор аймгийн 2020 оны төсвийг 245.9 сая төгрөгөөр бууруулж, 20,554.8 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь Ковид-19 цар цахлын улмаас төсөвт тодотгол хийж, байгууллагуудын төсвөөс хэмнэгдсэн зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 20,554.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 17,498.2 сая төгрөгийг урсгал зардалд, 2,779.4

сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 277.2 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 9,333.6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,139.9 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 9,463.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 47.4 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 256.9 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 313.5 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 9,333.6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 9,463.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийт 18,797.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож, 1,016.0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 43.7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, урьд оны үлдэгдлээс 313.5 сая, нийт 1,373.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 127.7 сая төгрөгийг ОНХНС болон Шивээговь сумын орон нутгийн орлогоос дутуу санхүүжүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 201.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 18.1 сая төгрөгөөр тасарсан нь ковид 19 цар тахалтай холбоотойгоор иргэдийн бизнесийн үйл ажиллагаа зогссоноос зээлээ төлөөгүй, СХС-гийн болон БТСГ-ын өөрийн орлогын төлөвлөгөө биелээгүйгээс шалтгаалжээ.

Туслах үйл ажиллагааны орлого 29.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 8.7 сая төгрөгөөр тасарсан нь ковид-19 цар тахалтай холбоотойгоор иргэдийн бизнесийн үйл ажиллагаа зогссоноос зээлээ төлөөгүй, авто замын сангийн өөрийн орлогын төлөвлөгөө биелээгүйгээс шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтын 11 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлээр 4,406.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, 12.6 сая төгрөгийг барьцаа дансанд, 30.8 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 2.1 сая, дээд шатны төсвийн захирагчаас 709.2 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 264.6 сая, нийт 975.9 сая төгрөгийн орлогыг бүртгэж тайлагнасан байна.

Үүнээс цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 27.2 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 3.4 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 15.1 сая, хангамж, бараа материалын зардалд 85.9 сая, нормативт зардалд 15.9 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 29.1 сая, томилолт, зочны зардалд 3.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 270.1 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 317.5 сая, бусад урсгал шилжүүлгийн зардалд 46.3 сая, олгосон санхүүжилт, шилжүүлгийн зардалд 162.3 сая, нийт 975.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Үүнээс урьд оны авлагад тооцон төвлөрүүлсэн ГХБХБГ-ын 20.0 сая, аймгийн ЗДТГ-ын нэмэлтийн үлдэгдэл 21.9 сая нийт 41.9 сая төгрөгийг буцаан олгосон байна. БТСУХ-ноос цахим фитнесийн тоног төхөөрөмж худалдан авах 13.1 сая, БОАЖЯ-наас 1.0 сая, АЗДТГ 4.0 сая, Сүмбэр сумын ЗДТГ 90.0 сая, нийт 108.1 сая төгрөгийг жилийн эцэст санхүүжилт орж ирснээс шалтгаалан хугацаа нь дуусаагүй ажлын үлдэгдэл санхүүжилт олгогдоогүй үлдсэн тул авлагад тооцон төвлөрүүлсэн байна.

ТЕЗ-ийн тайланд нийт давхардсан ажил гүйлгээ болох 262.0 сая төгрөгийн устгах бичилт хийж, цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 147 мэдээллээс 137 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 46.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 0.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 43.2 сая төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3.2	1	3.2			
Албан шаардлага	1	0.9	1	0.9			
Зөвлөмж	5	42.3	4	42.3	1		
Нийт	7	46.4	6	46.4	1		

Хэрэгжээгүй зөвлөмж нь аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дансны авлага, өглөгийг бууруулж ажиллах зөвлөмж байна.

3.9 Аудитын явцад ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 34 төсвийн байгууллага, 6 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 12 тусгайн сангийн, 3 төсвийн төвлөрүүлэн захирагчийн нийт 55 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 41 байгууллагад дүгнэлт гаргаж, 9 байгууллага түүвэрт хамрагдсан, 3 байгууллагад итгэл үзүүлсэн, 2 байгууллага аудитад хамрагдаагүй байна. Энэ тусгайлан төсөв батлагдаагүй Баянтал сумын МХС, БХС-гууд тул аудитад хамруулаагүй.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт 36, “Хязгаарлалттай” санал дүгнэлт 2 /аймгийн Боржигин чуулга, Баянтал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч/, “сөрөг” саналт дүгнэлт 2 /аймгийн “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ, Баянтал сумын Эрүүл мэндийн төв/, “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” 1 /Шивээговь сумын “Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ/ тус тус өгсөн байна.

Аудитаар нийт 79.1 сая төгрөгийн 9 алдаа, зөрчил илрүүлснээс 5.8 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 73.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмжийг хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 5.1 сая төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогод ангилал зөрүүтэй нэгтгэсэн
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 0.7 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг дээд шатны төсвөөс доод шатны төсөв захирагчид хуваарилсан хөрөнгө дансанд ангилал зөрүүтэй нэгтгэсэн

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:

1. Аймгийн Засаг даргын нөөц сангаас иргэнд олгосон 0.2 сая төгрөгийн шагналаас 10 хувийн татвар болох 0.02 сая төгрөгийг суутган тооцоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна” гэж заасныг тус тус зөрчсөн бөгөөд үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2. Аймгийн Ахмадын хороо нь ХХОАТ-ын хөнгөлөлтийг нийт 0.05 сая төгрөгөөр \илүү 0.024.0 сая, дутуу 0.025 сая\ зөрүүтэй тооцож олгосон зөрчил илэрсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба үнэн зөв иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

3. Аймгийн Ахмадын хороо нь татварын тайланд тооцоог хянаж баталгаажуулаагүйгээс ХХОАТ-ын 0.1 сая төгрөгийн авлагыг барагдуулж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн ба үнэн зөв байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

4. Аймгийн Ахмадын хороо нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулахтай холбоотой 1 тушаал шийдвэрийг дутуу оруулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 7 дугаар зүйлийн 7.1.1-т “Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй

адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан”, 7.1.3-т “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5-д “шилэн дансны нэгдсэн цахим хуудасны бүх түвшний хэрэглэгчид дараах үүрэгтэй” гэсэн заалтуудыг зөрчсөн ба үнэн зөв байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн:Зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

5. Аймгийн Авто замын сан нь авто замын их засварын 32.2 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээний хугацааг 2020.06.02 хүртэл сунгасан боловч сунгалтын хугацаа дууссан байхад ажлыг хүлээн аваагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4-т “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах”, 46.1.6-д “гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэснийг тус тус зөрчсөн ба үнэн зөв байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн:Зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

6. Аймгийн Засаг даргын нөөц сангаас хөрөнгө зарцуулахтай холбоотой аймгийн Засаг даргын нийт 39 захирамжийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 7 дугаар зүйлийн 7.1.1-т “Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан”, 7.1.3-т “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5-д “шилэн дансны нэгдсэн цахим хуудасны бүх түвшний хэрэглэгчид дараах үүрэгтэй” гэсэн заалтуудыг зөрчсөн ба үнэн зөв байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн:Зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Төсвийн ерөнхийлөн захирагчид 73.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 8 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4,393.2 сая төгрөгийн 451 алдаа, зөрчил илрүүлснээс 3,281.0 сая төгрөгийн 222 алдааг аудитын явцад залруулж, 73.8 сая төгрөгийн 11 алдаа, зөрчлийг залруулаагүй, 73.5 сая төгрөгийн 56 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 653.9 сая төгрөгийн 73 зөрчлийг арилгах албан шаардлага

хүргүүлж, 311.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 89 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Өмнөх оны төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5.699.0 сая төгрөгийн 398 алдаа зөрчил илэрч, 2,984.3 сая төгрөгийн 181 алдааг аудитын явцад залруулж, 60.4 сая төгрөгийн 33 төлбөрийн акт тогтоож, 470.9 сая төгрөгийн 50 албан шаардлага хүргүүлж, 2,183.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 134 зөвлөмж өгсөн байна.

Тайлант оны алдаа, зөрчлийн дүн өмнөх оноос 1,226.7 сая төгрөгөөр буюу 21.5 хувиар, зөвлөмжийн дүн 1,872.5 сая төгрөгөөр тус тус буурсан боловч актын дүн 13.1 сая, албан шаардлага 183.0 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

3.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд анхаарал татахуйц дараахь асуудал байна.

ОНӨААТҮГ-уудтай гэрээ байгуулаагүй, үйл ажиллагаанд нь хяналт тавиагүй, сумдын СХС-гийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй, санхүүгийн ажилтнууд тогтвор суурьшилтай ажиллаагүй, мэргэшүүлэх сургалт, зөвлөгөө хангалтгүй, санхүүгийн тайлан гаргахын өмнө аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс нэгдсэн арга зүйгээр хангах үйл ажиллагаа дутмаг байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Орлогын данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт: 3 төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө 16.9 сая төгрөгөөр тасарсан байна.

4.1.2 Эрсдэл: Хуулиар хүлээсэн чиг үүрэг хэрэгжихгүй байх

4.1.3 Өгсөн зөвлөмж: Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1 дэх заалтуудыг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул төсөвт байгууллагын орлогын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж батлуулах, батлагдсан орлогын төлөвлөгөөг бүрэн төвлөрүүлж ажиллах

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвшөөрсөн

4.2 Орлогын данстай холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт: Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ биелсэн боловч 5 нэр төрлийн татварын орлого 64.0 сая төгрөгөөр тасарсан, хуулиар тогтоосон татварын орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

4.2.2 Эрсдэл: Хуулиар хүлээсэн чиг үүрэг хэрэгжихгүй байх

4.2.3 Өгсөн зөвлөмж: Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.3, 23.6.8, 23.6.9, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1 дахь заалтуудыг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул татварын орлогын төлөвлөгөөг нэр, төрлөөр нь бүрэн биелүүлж ажиллах

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвшөөрсөн

4.3 Орлогын данстай холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт: Татварын бус орлого болох түрээсийн орлогын төлөвлөгөө 9.3 сая төгрөгөөр тасарсан байна.

4.3.2 Эрсдэл: Хуулиар хүлээсэн чиг үүрэг хэрэгжихгүй байх

4.3.3 Өгсөн зөвлөмж: Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1 дахь заалтуудыг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул татварын бус орлогын төлөвлөгөөг нэр, төрлөөр нь бүрэн биелүүлж ажиллах

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвшөөрсөн

4.4 Удирдлагын дээд ба дотоод хяналттай холбоотой асуудал

4.4.1 Илрүүлэлт: Аймгийн Ахмадын хороо нь цахим төлбөрийн системд худалдан авалтын мэдээлэл тохирч байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаагүй.

4.4.2 Эрсдэл: Хяналтгүй гүйлгээ хийгдэх, татвар төлөгч татвараас зайлсхийх

4.4.3 Өгсөн зөвлөмж: Энэ нь нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5-д заасныг хэрэгжүүлж, татварын цахим бүртгэлийн системээр зарцуулалтыг хянах

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.5 Орлогын данстай холбоотой асуудал

4.5.1 *Илрүүлэлт:* аймгийн Автозамын сан нь сангийн орлогын төлөвлөгөөг 3.0 сая төгрөгөөр тасалсан байна.

4.5.2 *Эрсдэл:* Үндэслэлтэй төлөвлөөгүйгээс орлогын төлөвлөгөө тасрах, хуулиар хүлээсэн чиг үүрэг хэрэгжихгүй байх

4.5.3 *Өгсөн зөвлөмж:* Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1 дэх заалтуудыг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул орлогын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж батлуулах, батлагдсан орлогын төлөвлөгөөг бүрэн төвлөрүүлж ажиллах

4.5.4 *Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:* Зөвшөөрсөн

4.6.Балансын данстай холбоотой асуудал

4.6.1 *Илрүүлэлт:* аймгийн Автозамын сан нь санхүүгийн тайланд тусгагдсан 16.0 сая төгрөгийн авлагыг барагдуулж ажиллаагүй байна.

4.6.2 *Эрсдэл:* Сангийн үйл ажиллагаа алдагдах, байгууллагын удирдлага хариуцлага хүлээх эрсдэлтэй

4.6.3 *Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж, дансны авлагыг барагдуулж ажиллах

4.6.4 *Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

4.7 Зардлын данстай холбоотой асуудал

4.7.1. *Илрүүлэлт:* Аймгийн Засаг даргын нөөц сангаас 3 иргэнд жуух бичгийн дагалдах мөнгөн шагналыг гарын үсэг зуруулалгүй, анхан шатны баримтын бүрдэлт дутуу олгосон байна.

4.7.2. *Эрсдэл:* Төсвийн хөрөнгө үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулагдах, байгууллагын удирдлага хариуцлага хүлээх

4.7.3. *Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.7 дахь заалтуудыг хэрэгжүүлж, анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллах

4.7.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

4.8 Балансын данстай холбоотой асуудал

4.8.1. *Илрүүлэлт:* Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэхдээ төсвийн гүйцэтгэл болон нэмэлт санхүүжилтийн тайланг хянаж хүлээн аваагүй, эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн, төрийн сангаас хянаж хийсэн гүйлгээний утга нь байгууллагуудын анхан шатны баримт бувуу төлбөрийн хүсэлтийн гүйлгээний утгаас зөрүүтэй шивэгдсэн.

4.8.2 *Эрсдэл:* Бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүйгээс удирдлага хариуцлага хүлээх

4.8.3 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Засгийн газрын 2014 оны 326, 2019 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын 1 дүгээр зүйлийн 1.1.3, 1.1.10 дахь заалтуудыг зөрчсөн, үнэн зөв байх, батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул нэгтгэлд хамрагдаж буй байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалтад хамруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах

4.8.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвшөөрсөн

4.9 Зардлын данстай холбоотой асуудал

4.9.1. Илрүүлэлт: Аймгийн Лаборатори 5 дугаар сургууль нь аймгийн харьяаны статустай байгууллага боловч сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь хэрэгжиж, тайлан нэгтгэгдэж байгаа нь хууль журамд нийцэхгүй байна.

4.9.2 Эрсдэл: Хууль тогтоомж зөрчигдөх, байгууллагын удирдлага хариуцлага хүлээх

4.9.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1, 6.6.2 дахь заалтуудыг хэрэгжүүлж, ТЕЗ-ийн харьяанд төсөв санхүүгийн болон тайлан нэгтгэх үйл ажиллагааны зохицуулалт хийх арга хэмжээ авах

4.9.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвшөөрсөн

4.10 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.10.1. Илрүүлэлт: ТЕЗ нь аймгийн харьяа байгууллагуудын үр дүнгийн гэрээг дүгнэж босоо удирдлагатай газрын дарга нарт үр дүнгийн урамшуулал олгох захирамж гаргасан нь дээд шатны байгууллагын урамшуулал олгох тушаалтай давхардаж төлбөрийн акт тогтоогдсон.

4.10.2 Эрсдэл: Хууль тогтоомж зөрчигдөх, шийдвэр гаргасан эрх бүхий этгээд хариуцлага хүлээх, акт төлбөр тогтоогдох

4.10.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 40 дүгээр зүйлийн 40.2.3, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 14 дүгээр зүйлийн 14.2.3, "үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид дээд шатны захирагчаас урамшууллын шийдвэр гаргадаг байгууллагуудад урамшуулал олгох шийдвэрийг давхардуулан гаргахгүй байх

4.10.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвшөөрсөн

4.11 Балансын данстай холбоотой асуудал

4.11.1. Илрүүлэлт: ОНХС болон улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлыг бүртгэлжүүлэх ажлын хяналт хангалтгүй, бүртгэлжүүлэхээр гаргасан шийдвэрийн хавсралтад хэрэгжүүлсэн ажлын үнийн дүнг зөрүүтэй болон дутуу тусгаж гаргасан, хөрөнгийг бүртгэхтэй холбоотой зөрчил жил бүр давтагдсаар байна.

4.11.2 Эрсдэл: Хөрөнгө үнэгүйдэх, эзэнгүйдэх, данс бүртгэлд тусгахгүй байх

4.11.3 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, “Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

4.11.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвшөөрсөн

4.12 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.11.1. Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдэж буй ОНӨААТҮГ-уудтай ТЕЗ-аас гэрээ байгуулаагүй, орлого, зарлагын төлөвлөгөө батлагдаагүйгээс ажлын гүйцэтгэлийг харьцуулах шалгуур үзүүлэлт байхгүй, ажил дүгнэсэн үнэлгээ байхгүй, үйл ажиллагааны үр дүн сайжрахгүй байна.

4.12.2 Эрсдэл: ОНӨААТҮГ-ын хэвийн үйл ажиллагаа алдагдах, хууль тогтоомж зөрчигдөх, байгууллагын удирдлага, эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээх

4.12.3 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 78 дугаар зүйлийн 78.2 дахь заалтуудыг хэрэгжүүлж, ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг сайжруулж ажиллах

4.12.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.04.19	Аудитын нэр:	Говьсүмбэр аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: ГСА-2021/1/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд Боржигин чуулгын туслах үйл ажиллагааны орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогоор ангилал зөрүүтэй нэгтгэсэн.	5.1	Залруулах	Засаг дарга, СТСХ-ийн дарга ерөнхий санхүүч	Г.Батзам А.Отгонтуяа Б.Соёлмаа
2	Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд Сум дундын ойн ангийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг дээд шатны төсвөөс доод шатны төсөв захирагчид хуваарилсан хөрөнгө дансанд ангилал зөрүүтэй нэгтгэсэн.	0.7	Залруулах	Засаг дарга, СТСХ-ийн дарга ерөнхий санхүүч	Г.Батзам А.Отгонтуяа Б.Соёлмаа
3	Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө бүрэн биелээгүй, /БТСГ," Цөм сүргийн үржлийн төв" ТӨҮГ, Автозамын сан/		Зөвлөмж өгөх	Засаг дарга, СТСХ-ийн дарга ерөнхий санхүүч	Г.Батзам А.Отгонтуяа Б.Соёлмаа
4	Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ биелсэн боловч 5 нэр төрлийн татварын орлого биелээгүй, хуулиар тогтоосон татварын орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй.	64.0	Зөвлөмж өгөх	Засаг дарга, СТСХ-ийн дарга ерөнхий санхүүч	Г.Батзам А.Отгонтуяа Б.Соёлмаа
5	Татварын бус орлого болох түрээсийн орлогын төлөвлөгөө биелээгүй	9.3	Зөвлөмж өгөх	Засаг дарга, СТСХ-ийн дарга ерөнхий санхүүч	Г.Батзам А.Отгонтуяа Б.Соёлмаа
6	ТЕЗ нь аймгийн харьяа байгууллагуудын үр дүнгийн гэрээг дүгнэж босоо удирдлагатай газрын дарга нарт үр дүнгийн урамшуулал олгох захирамж гаргасан нь дээд шатны байгууллагын урамшуулал олгох тушаалтай давхардаж төлбөрийн акт тогтоогдсон тул цаашид дээд шатны	-	Зөвлөмж өгөх	Засаг дарга,	Г.Батсуурь Ш.Билэггүмбэ рэл Г.Батзам

Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	захирагчаас урамшууллын шийдвэр гаргадаг байгууллагуудад урамшуулал олгох шийдвэрийг давхардуулан гаргахгүй байх				
7	ОНХС болон улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлыг бүртгэлжүүлэх ажлын хяналт хангалтгүй, бүртгэлжүүлэхээр гаргасан шийдвэрийн хавсралтад хэрэгжүүлсэн ажлын үнийн дүнг зөрүүтэй болон дутуу тусгаж гаргасан, хөрөнгийг бүртгэхтэй холбоотой зөрчил жил бүр давтагдсаар байна.	-	Зөвлөмж өгөх	Засаг дарга, СТСХ-ийн дарга ерөнхий санхүүч	Г.Билэггүмбэр рэл Г.Батзам А.Отгонтуяа Б.Соёлмаа
8	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэхдээ төсвийн гүйцэтгэл болон нэмэлт санхүүжилтийн тайланг хянаж хүлээн аваагүй, эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн, бүртгэл тайлагналд хяналт тавиагүй зөрчил давтан гаргасан, төрийн сангийн гүйлгээний утга нь байгууллагуудын анхан шатны баримтын гүйлгээний утгаас зөрүүтэй шивэгдсэн.	-	Зөвлөмж өгөх	Засаг дарга, СТСХ-ийн дарга ерөнхий санхүүч	Г.Батзам А.Отгонтуяа Б.Соёлмаа
9	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдэж буй ОНӨААТҮГ-уудтай ТЕЗ-аас гэрээ байгуулаагүй, орлого, зарлагын төлөвлөгөө батлагдаагүйгээс ажлын гүйцэтгэлийг харьцуулах шалгуур үзүүлэлт байхгүй, ажил дүгнэсэн үнэлгээ байхгүй, үйл ажиллагааны үр дүн сайжрахгүй байгаад анхаарах	-	Зөвлөмж өгөх	Засаг дарга, СТСХ-ийн дарга ерөнхий санхүүч,	Г.Батсуурь Г.Батзам А.Отгонтуяа Б.Соёлмаа
10	Аймгийн Лаборатори 5 дугаар сургууль нь аймгийн харьяаны статустай байгууллага боловч сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь хэрэгжиж, тайлан нэгтгэгдэж байгаа нь хууль журамд нийцэхгүй байгаа тул ТЕЗ-ийн харьяанд төсөв санхүүгийн болон тайлан нэгтгэх үйл ажиллагааны зохицуулалт хийх арга хэмжээ авах		Зөвлөмж өгөх	Засаг дарга, СТСХ-ийн дарга ерөнхий санхүүч	Г.Батсуурь А.Отгонтуяа Б.Соёлмаа
	Дүн	79.1			

Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудит Баримал нэр: _____

Аудит Баримал дугаар: _____

Аудит нэр: _____

Заруулмагд буюу шаардсан буюу өндөр зөрчилт асуудал бүртгэл

БЭН | Аудит нэр | ГСАНХҮҮСТА-ТЭЗ | Төрийн

Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

№	Аудитын нэр	Тоо	Алдаа, зөрчилт тэмдэгт	Зөрчилтөн түүний ажил	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шалтгаал	Аудит үйлчилгээний байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн санал, тайлбар	Гаргасан шалтгаал	Зөвчүүлсэн байгууллагын төлөвс мэдэл, мөнгөний асуудлыг гаргуулсан хүний	
										Ахуйн түвшин	Одоогийн
1	2	3	4	5	6	7	8	9	10		
1	Орлогын данс	1	Нэгдсэн санхүүгийн үр дүнгийн тайланг Борооно нүүлгэн үзсэн үйл ажиллагааны орлого үндсэн үйл ажиллагааны орлогоор өнцөгдөл зөрүүлж нэгтгэсэн.	Нэгдсэн борло бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төсвийн тухай хуулийн 54 дугаар зүйлийн 54.3 дэх заалт, "үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдэлийг хангалтгүй байна.	5,091,100.00	Зогсож өгсө	Зөвшөөрсөн	Зогсож өгсө		Засаг дарга, Санхүүгийн төрийн сангийн хэлтсийн дарга, Ерөнхий санхүүч	Г.Батлам, А.Отгонтуяа, Б.Соёлмаа
2	Төсвийн данс	1	Нэгдсэн мөнгөн гүйцэтгэлийн тайланг Сум дундын ойр дундын үндсэн үйл ажиллагааны хүрээнд байр болсон өнцөгт орлогын дээд шатны төлөвс дотоод шатны төлөвс тусламжид тусгаарласан өрнөлт дансанд өнцөгдөл зөрүүлж нэгтгэсэн.	Нэгдсэн борло бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төсвийн тухай хуулийн 54 дугаар зүйлийн 54.3 дэх заалт, "үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдэлийг хангалтгүй байна.	710,000.00	Зөвшөөрсөн	Зөвшөөрсөн	Зогсож өгсө		Засаг дарга, Санхүүгийн төрийн сангийн хэлтсийн дарга, Ерөнхий санхүүч	Г.Батлам, А.Отгонтуяа, Б.Соёлмаа
3	Орлогын данс	1	Төсвийн байгууллагын өөрийн орлогын төлөвсөөс бусад биетүүд, тэдгээрийн дүн орлогын хэргийн төл, БТС, АТЗ-ийн сан	Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.2, 23.8.8, 23.8.14, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1, Засаг дарга 2014 оны 326, 2019 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан "Санхүүгийн албаны зохион байгуулалт, нэг үүрэг, орон тооны жижиг норматив"-ын 1 дүгээр зүйлийн 1.1.8 дэх заалтуудад зөрчсөн ба АСУС 210 "хөдөөтэй", "үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдэлийг хангалтгүй байна.		Зөвлөх өгсө	Зөвшөөрсөн	Зөвлөх өгсө	Зөвлөх өгсө	Засаг дарга, Санхүүгийн төрийн сангийн хэлтсийн дарга, Ерөнхий санхүүч	Г.Батлам, А.Отгонтуяа, Б.Соёлмаа
4	Орлогын данс	1	"Төлөвс орлогын төлөвсөөс нийт дундаар биетүүд болон 5-аар төрийн татварын орлого биетүүд, үүнийг тогтоосон төлөвс орлогын биетүүд өнцөгт тэмдэгт хангалтгүй.	Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.2, 23.8.8, 23.8.14, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1, Засаг дарга 2014 оны 326, 2019 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан "Санхүүгийн албаны зохион байгуулалт, нэг үүрэг, орон тооны жижиг норматив"-ын 1 дүгээр зүйлийн 1.1.8 дэх заалтуудад зөрчсөн ба АСУС 210 "хөдөөтэй", "үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдэлийг хангалтгүй байна.	64,548,780.00	Зөвлөх өгсө	Зөвшөөрсөн	Зөвлөх өгсө	Зөвлөх өгсө	Засаг дарга, Санхүүгийн төрийн сангийн хэлтсийн дарга, Ерөнхий санхүүч	Г.Батлам, А.Отгонтуяа, Б.Соёлмаа
5	Орлогын данс	1	Төлөвс бус орлого болох түрээсийн орлогын төлөвсөөс биетүүд	Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.2, 23.8.8, 23.8.14, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1, Засаг дарга 2014 оны 326, 2019 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан "Санхүүгийн албаны зохион байгуулалт, нэг үүрэг, орон тооны жижиг норматив"-ын 1 дүгээр зүйлийн 1.1.8 дэх заалтуудад зөрчсөн ба АСУС 210 "хөдөөтэй", "үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдэлийг хангалтгүй байна.	9,291,106.00	Зөвлөх өгсө	Зөвшөөрсөн	Зөвлөх өгсө	Зөвлөх өгсө	Засаг дарга, Санхүүгийн төрийн сангийн хэлтсийн дарга, Ерөнхий санхүүч	Г.Батлам, А.Отгонтуяа, Б.Соёлмаа
6	Цалингийн зардал	1	ТЭЗ нь аймгийн харьяа байгууллагад үр дүнгийн орлого дүнгийн босоо үндэслэлтэй газрын дарга мөрт үр дүнгийн үржүүлэлт өгсө захирамж гаргасан нь дээд шатны байгууллагын үржүүлэлт өгсө тусламжтай давхардан төлбөрийн илт тогтоосон тус ашигд дээд шатны захирамжаас үржүүлэлт өгсөдөөс гаргаж байгууллагад үржүүлэлт өгсө шийдвэрийн давхардуулан гаргасгүй байх.	Нэгдсэн борло бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Захирагчийн Ерөнхий тухайн 37 дугаар зүйлийн 37.1, 40 дугаар зүйлийн 40.2.3, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 14 дүгээр зүйлийн 14.2.3 заалтуудад зөрчсөн ба "үнэн зөв байх" батламж мэдэгдэлийг хангалтгүй байна.		Зөвлөх өгсө	Зөвшөөрсөн	Зөвлөх өгсө	Зөвлөх өгсө	Засаг дарга,	Ш.Билэгтүвшин, Г.Батлам, Г.Батлам
7	Хүндийн зардал	1	ОНХС болон үрэг орон нутгийн төсвийн зардалаар сэрээлүүлсэн ахуй бүртгэжүүлсэн ахуйн өнцөгт хөдөөтэй, бүртгэжүүлсэн гаргасан шийдвэрийн хөдөөтэй хөдөөтэй ахуйн үндсэн дүнг заруулж болон дутуу тусгаж гаргасан, зөрчилт бүртгэжүүлж холбоотой зөрчил жил бүр давтагдаж байна.	Нэгдсэн борло бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20.2.6, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зардалаар сэрээлүүлсэн төлөвс, санхүүжилт, өнцөгт, тайлбарын зардал"-ын 8 дугаар зүйлийн 8.1, дэх заалтуудад зөрчсөн ба "үнэн зөв байх" батламж мэдэгдэлийг хангалтгүй байна.		Зөвлөх өгсө	Зөвшөөрсөн	Зөвлөх өгсө	Зөвлөх өгсө	Засаг дарга, Санхүүгийн төрийн сангийн хэлтсийн дарга, Ерөнхий санхүүч	Ш.Билэгтүвшин, Г.Батлам, А.Отгонтуяа, Б.Соёлмаа

Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

8	Санхүүгийн нэгтгэсэн тайлан	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгсэл байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн авч нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл болон нэгтгэл санхүүжилтийн тайланг өмнө үзсэн ажлууг, эдийн засгийн ажиллагааг мөрдөн гүйцэтгэсэн, бүртгэл тайлангаар хяналт тавиагүй зарим дагалдсан зардал, төрийн сангийн гүйцэтгэлийн үйлчилгээний байгууллагуудын зардал шалгах баримтын гүйцэтгэлийн үйлчилгээний байгуулсан.	Нэгжлэн бодол бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Засгийн газрын 2012 оны 225 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйлчилгээний хууль" -ын 5 дугаар зүйлийн 6.4, Засгийн газрын 2014 оны 328, 2018 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Санхүүгийн албан хаагчийн байгуулалт, нэг үүрэг, орон тооны хяналт хяналт" -ын 1 дугаар зүйлийн 1.1.3, 1.1.5, 1.1.10 дэх заалтуудыг мөрдөж ба үнэн зөв байх, нэг бүрэн байх батламж үзүүлж гүйцэтгэж байна.		Зөвөлмө өгсн	Зөвөлмө өгсн	Зөвөлмө өгсн	Зөвөлмө өгсн	Засаг дарга, Санхүүгийн төрийн сангийн хяналтын дарга, Ерөнхий санхүү	Г.Батлам, А.Осломуу, Б.Солонго
9	Хууль тогтоомжийн гэрээлэлт	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланг нэгтгэсэн бэй ОМБААТТ-руудтай ТЭЗ-аас гэрээ байгуулахгүй, эрхлэл, зарлигын төлөвлөгөө батлагдахгүйгээр зардал, гүйцэтгэлийн зардалаар шалгуур үзүүлэлт байгуу, өмнө дүнчилсэн үйлчилгээ байгуу, үйлчилгээний үйлчилгээний байгуулсан байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19.1, 19.2.1, 19 дугаар зүйлийн 78.2 дэх заалтуудтай нийцүүлж байна.		Зөвөлмө өгсн	Зөвөлмө өгсн	Зөвөлмө өгсн	Зөвөлмө өгсн	Засаг дарга, Санхүүгийн төрийн сангийн хяналтын дарга, Ерөнхий санхүү	Г.Батлам, Г.Батлам, А.Осломуу, Б.Солонго
10	Нэгжлэн санхүүгийн тайлан	Мөнгөн Габбаргаруу 5 дугаар зургууль нь өмчийн зардалын стансуудтай байгуулаха болон өмчийн төлөөлөгчид захирагчийн хяналтад төсөв санхүүгийн үйлчилгээний үйлчилгээний байгуулсан байна нь зардал, гүйцэтгэлийн зардалаар шалгуур үзүүлэлт байгуу, өмнө дүнчилсэн үйлчилгээний байгуулсан байна.	Нэгжлэн бодол бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6.5, 6.5.2 дэх заалтуудтай нийцүүлж байна.		Зөвөлмө өгсн	Зөвөлмө өгсн	Зөвөлмө өгсн	Зөвөлмө өгсн	Засаг дарга, Санхүүгийн төрийн сангийн хяналтын дарга, Ерөнхий санхүү	Г.Батлам, А.Осломуу, Б.Солонго
Нийт дүн				79,141,968.00						

Батлагдсан:

Ахлах ажилтан  /У.Батбаяр/ 2021.04.17

Ахлах ажилтан  /П.Баяр/ 2021.04.18

Ахлах ажилтан  /П.Баяр/ 2021.04.18

Ахлах ажилтан  /П.Баяр/ 2021.04.18

Төрийн ажилтан  /Б.Сарантуяа/ 2021.04.18

Төрийн сангийн үйлчилгээний хууль

Мөнгөн ТЭЗ  /М.Тсэвэг/ 2021.04.18

Санхүүгийн төрийн сангийн хяналтын дарга  /Г.Батлам/ 2021.04.18

Ерөнхий санхүү  /Б.Солонго/ 2021.04.18